210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	721,991.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>265,428,839.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,324,839.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>89,877,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,114,800.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,876,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,230,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,008,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>53,763,100.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	53,763,100.00
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>398,962,867.90</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>398,962,867.90</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,543,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	341,549,779.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,870,088.90

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд татварын орлогын болон зээлийн авлагын мэдээ тайлан гаргалттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/102 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Лүн сум нь тайлант онд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө бага байна.

Лүн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388, 2015 оны 341 тоот тушаалаар баталсан загвар, аргачлалыг баримтлан тайлагнаж байна.

Лүн сумын Засаг даргын захирамжаар томилогдсон 5 хүний бүрэлдэхүүнтэй баг хяналтыг хэрэгжүүлдэг байна. Аймгийн Засаг даргаас жилд 2 удаа бүх сум байгууллагад нэрэмжит үзлэг, Санхүүгийн хяналт аудитын алба удирдамж төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулдаг, байгууллага бүрд дотоод хяналтын нэгж ажилладаг боловч сумын хэмжээнд төсөв санхүүгийн сахилга бат сайжирч, алдаа зөрчил буурахгүй байна. Цаашид анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Лүн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн тайлангийн мөнгөн гүйлгээний нийт зарлагыг суурь үзүүлэлтийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,669,228.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 55,038.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 44,030.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатанд тооцсон материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэж хэвээр үлдээсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Лүн сумын Засаг дарга нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ЗЗНДНТУТХ, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хууль болон холбогдох бусад хууль дүрэм зааврыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсөвт байгууллага, төрийн сан, Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан, Эмийн эргэлтийн сан, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан зэрэг 11 санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнасан байна.

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд Сангийн яамны Э тайлангийн нэгтгэлийн систем програмыг ашиглаж байна.

#### ***Орлогын талаар:***

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа байгууллагууд тусгай зориулалтын шилжүүлгээс 1,477,299.8 мянган төгрөг, орон нутгийн төсвийн 644,574.2 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалаас 22,626.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 73,908.1 мянган төгрөг, Төсөвт байгууллагын өөрийн орлого 121,290.3 мянган төгрөг, торгуулийн орлого 351,104.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 391,463.6 мянган төгрөг, татварын орлого 235,156.8 мянган төгрөг, нийт 3,319,419.0 мянган төгрөгийн орлого, эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Лүн сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг нийт 393,569.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн төсөвт 2021 онд татварын орлого 235,156.8 мянган төгрөг, татварын бус орлого 351,193.0 мянган төгрөг, нийт 586,832.8 мянган төгрөг төвлөрч, батлагдсан төлөвлөгөөг 193,263.2 мянган төгрөг буюу 1.5 дахин биелүүлсэн байна. Орон нутгийн орлогын төлөвлөгөө өндөр хувиар биелэхэд сумын Засаг даргатай байгуулсан Идлэг шонхор шувуу бариулах тухай гэрээний дагуу 174,550.1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн нь нөлөөлсөн байна.

**Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансанд 25,508.1 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 170,611.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор нийт 196,119.8 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн ба 22,496.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассан байна.

Бараа материалын дансанд худалдан авсан 419,513.7 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хүлээн авсан 675,457.3 мянган төгрөгийн, нийт 675,457.3 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 614,926.4 мянган төгрөгийн бараа материалыг хассан байна

**Авлага, өглөгийн талаар:**

Санхүүгийн нэгтгэсэн тайланд байгууллагаас авах 73,086.6 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангийн авлага 22,728.3 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн авлага 242,298.6 мянган төгрөг, ажилчидтай холбогдсон авлага 12.6 мянган төгрөг, нийт 321,636.6 мянган төгрөгийн авлага нэгтгэгдсэн байна. Нийт авлагын 242,298.6 мянган төгрөг буюу 75,0 хувийг сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага эзэлж байна.

Бараа үйлчилгээний зардлын өглөг 177.9 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 4,536.2 мянган төгрөг, нийт 4,714.2.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй нэгтгэгдсэн байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн харилцах дансанд 344,701.8 мянган төгрөг, арилжааны банк дахь харилцах дансанд 5,542.6 мянган төгрөг, нийт 350,244.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэгтгэгдсэн байна.

Бараа материал 249,285.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 8,988,817.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Мөнгөн хөрөнгө</b>	94,709.9	350,244.4	255,534.4
<b>Авлага</b>	311,061.6	321,636.6	10,575.0
<b>Урьдчилгаа</b>			
<b>Бараа материал</b>	188,754.7	249,285.5	60,530.8
<b>Үндсэн хөрөнгө</b>	9,382,405.3	8,988,817.7	-393,587.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>9,976,931.7</b>	<b>9,909,984.4</b>	<b>-66,947.3</b>
<b>Өр төлбөр</b>	13,049.0	4,714.2	-8,334.8
<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	9,963,882.6	9,905,270.1	-58,612.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>9,976,931.7</b>	<b>9,909,984.4</b>	<b>-66,947.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 249,285.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 60,530.8 мянган төгрөгөөр өссөн нь эм, боох материал, бичиг хэрэг, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,988,817.7 мянган төгрөг болж 393,587.6 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,905,270.1 мянган төгрөг болж 58,612.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Лүн сумын ИТХ-ын Хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “2021 оны төсөв батлах тухай” 07 дугаар тогтоолоор 2021 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 393,569.6 мянган төгрөгөөр, зарлагын нийт хэмжээг 2,580,703.6 мянган төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор 2021 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийн хэмжээг 73,908.1 мянган төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг 1,493,250.0 мянган төгрөгөөр тус тус тодотгон баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн зарлагын нийт хэмжээг 2,833,555.3 мянган төгрөгийн төсөв баталсан.

Нийт зардлын 1,477,299.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 58,951.7 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдэлээс, 73,908.1 мянган төгрөгийг ОНХСангийн шилжих үлдэгдэлээс, 26,255.3 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,038,143.8 мянган төгрөгийг аймгийн төсвөөс тусгай зориулалтын шилжүүлэг, 158,996.6 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,471,896.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 86,934.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 46,015.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийн зардалд, нийт 2,604,846.4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 49,923.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,319,419.0 мянган төгрөг буюу 86,1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд санхүүгийн нэгтгэсэн тайланд 398,962.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн, бараа, ажил үйлчилгээний зардалд 309,084.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, дэмжлэг, урамшуулалд 89,877.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Лүн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллагууд, тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

- Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудиторуд нь тус сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан, эмийн эргэлтийн сангийн тайланг түүвэрт хамруулан шалгасан. Аудитаар ЗДТГ-т 2,236.3 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 29,934.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, ИТХ-д 2,214.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага, соёлын төвд 11,125.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, сум хөгжүүлэх санд 2,371.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 101,880.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, орон нутгийн хөгжлийн санд 71,118.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага тус тус өгөгдсөн.
- Төв аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр Гэрэлтэх бүртгэл аудит ХХК тус сумын ЕБС, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв гэсэн 3 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргасан. Аудитаар эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланд 5,904.1 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,400.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,286.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж, эрүүл мэндийн төвд 26.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 5,859.6 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 467,018.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, Ерөнхий боловсролын сургуульд 1,136.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 937,233.9 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 267.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж, Хүүхдийн цэцэрлэгт 2,153.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,977.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 281,239.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж тус тус хүргүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сумын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр биелүүлсэн боловч 7 нэр төрлөөр тасалсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Ерөнхий боловсролын сургуульд НДШ, ХХОАТ илүү дутуу суутгасан, хүнсний материал нөөцлсөн 1,136.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, Хүүхдийн цэцэрлэгт ХХОАТ дутуу суутгасан, хүнсний материал нөөцөлсөн 2,153.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, эргэлтийн эмийн санд 5,904.1 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 146 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 142 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 01/230 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлогын талаар дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч болон харъяа байгууллагуудын аудитаар нийт 2,060,579.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 103,244.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,221.2 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт, 1,092,626.6 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага, 855,486.8 мянган төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Засаг даргын Тамгын газар мөнгөн гүйгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авсан зардлыг хөрөнгийн зардлаар тайлагнаагүй, төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлэхдээ буруу кодоор тайлагнасан, үндсэн хөрөнгө орлогод аваагүй 82,600.7 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв 20,644.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хөрөнгийн зардлаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Ерөнхий боловсролын сургууль ХЧТА-ын акттай албан хаагчийг 1-10 сарын цалингаас ХХОАТ-ыг чөлөөлөлгүй тооцсоноос цалингаас ХХОАТ-ын 458,563.88 төгрөгийг илүү, 11-12 сард ХЧТА-ын акт дууссан байтал цалингаас НДШ-ийн 22,851.75 төгрөгийг дутуу, ХХОАТ-ын 4,285.18 төгрөгийг илүү буюу цалингаас нийт 439,997.31 төгрөгийг илүү суутгасан байна. Энэ

нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэсэн дагуу шийдвэрлэв.

Ерөнхий боловсролын сургууль Хүүхдийн хоол хүнсний зардлаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 697.0 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, материал нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэсэн дагуу шийдвэрлэв.

Хүүхдийн цэцэрлэг давхар ажил эрхэлдэг албан хаагчид ХХОАТ-т хөнгөлөлт тооцсоноос цалингаас ХХОАТ-ын 200.0 мянган төгрөгийг дутуу суутгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэсэн дагуу шийдвэрлэв.

Хүүхдийн цэцэрлэг Хүүхдийн хоол хүнсний зардлаас хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 1,953.8 мянган төгрөгийг нэгдсэн дансанд төвлөрүүлэлгүй, нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.2-т “төлөвлөсөн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас, эсхүл тоо хэмжээ нь буурснаас бий болсон үлдэгдэл” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэсэн дагуу шийдвэрлэв.

Эргэлтийн эмийн санчаас авах 5,904.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр

төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн дагуу шийдвэрлэв.

#### 4.3 Албан шаардлага

Соёлын төв, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, эргэлтийн эмийн сангийн харилцагч байгууллагатай хийсэн 15,740.0 мянган төгрөгийн худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1 “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг тооцоо хийж, баталгаажуулсан байдал болон зээлийн хугацаа хэтрэлтийг зээлдэгч бүрээр тулгахад 101,880.3 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын “толилуулга”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-дэх заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгөх гэсэн дагуу шийдвэрлэв.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## **1. Орлоготой холбоотой асуудал**

### **1.1. Илрүүлэлт:**

Сумын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр биелүүлсэн боловч ХХОАТ, бууны албан татвар, тэмдэгтийн хураамж, ус ашигласны төлбөр, хог хаягдал, гадрын төлбөр, төсөвт газрын өөрийн орлого гэсэн 7 нэр төрлөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлогын мэдээлэхдээ орлогын дансны хуулгыг боловсруулан үнэн зөв мэдээлж байх ба түүнд тавих хяналтыг сайжруулах

## **2. Тайлан, мэдээ гаргалттай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Сум хөгжүүлэх санхүүгийн тайлангийн авлагын үлдэгдлийг аймгийн ХХААГ-аас ирүүлсэн сангийн авлагын дүнтэй тулгахад 2,371.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн авлагын дүнг ХХААГ-ийн тайлангаас зөрүүтэй мэдээлж буй зөрчлийг арилгаж, зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдлийг зөрүүгүй үнэн зөв тайлагнаж байх.

## **3. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### **3.1. Илрүүлэлт:**

Эргэлтийн эмийн сан нь Монгол эм импекс ХХК-д өгөх 926.2 мянган төгрөгийн, Энто ХХК-д өгөх 360.0 мянган төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Цаашид өглөг үүсгэхгүй ажиллах.

## **4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**4.1. Илрүүлэлт:**

Орон нутгийн хөгжлийн сангийн харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Төв гэрэл ХХК-д шилжүүлсэн 2 ажлын 15,740.0 мянган төгрөгийн худалдан авалт нь цахим төлбөрийн баримтаар баталгаажаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ", санхүүгийн тайлангийн аудитын "Иж бүрэн байх", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалт бүрийг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулах.

**5. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**5.1. Илрүүлэлт:**

ОНХС-ийн эхний үлдэгдэл 19,205.7 мянган төгрөг байхад сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 07 тоот "Сумын 2021 оны төсөв батлах тухай" тогтоолд 10,147.5 мянган төгрөг буюу 9,058.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг батлалгүй орхигдуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хууль 5 дугаар зүйлийн 5.1.2-д заасан "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн зарчимд нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Эх үүсвэрийг сумын ИТХ-ын тогтоолоор бүрэн батлуулж байж зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Төв аймгийн Лүн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын асуудал

	Лүн Засаг дарга	31	2,060,579.5	5	103,244.8	6	9,221.1	9	1,092,626.6	11	855,486.8
--	-----------------	----	-------------	---	-----------	---	---------	---	-------------	----	-----------